**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**
**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ЖАРГАЛАНТ СУМЫН ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА-2021/131/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2021 он | Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: X khovd@audit.gov.mn<br>Аудитын менежер:<br>Утас: 70432545 Цахим хаяг:<br>Тунгалаг бүртгэл Аудит ХХК<br>Аудитор: Ч.Мөнхцооз<br>Утас: 99028555<br>Цахим хаяг:munhuu8555@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 11
3. Аудитын тайлан ........ 12
3.1. Ерөнхий зүйл ........ 12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ........ 13
3.4. Материаллаг байдал ........ 13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........ 15
3.7. Шилэн дансны мэдээлэл ........ 15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
3.9. Аудитын илрүүлэлт ........ 16
Залруулсан алдаа ........ 16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ........ 16
Аудитын зөвлөмж ........
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........ 16
4. Менежментийн захидал ........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 17

# 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 8/192
танай ____________ -ны № ____________ -т

ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Хот тохижуулах газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хот тохижуулах газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хот тохижилт үйлчилгээний чанар үр өгөөжийг дээшлүүлж, иргэдийн амьдрах зэлтэй орчин бүрдүүлэх зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан агуулсан байна. удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

021020400

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **20,193,576.00** | **24,672,993.00** |
| **33** | **АВЛАГА** | 2,084,336.00 | 10,892,173.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 406,336.00 | 289,079.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,678,000.00 | 1,678,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 8,925,094.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 18,109,240.00 | 13,780,820.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 18,109,240.00 | 13,780,820.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 359,500.00 | 362,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,807,000.00 | 10,010,500.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 370,000.00 | 122,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,572,740.00 | 3,286,120.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,776,193,307.98** | **1,751,620,442.34** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,776,193,307.98 | 1,751,620,442.34 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,696,200,307.98 | 1,671,749,192.30 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 669,887,215.06 | 669,887,215.06 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (198,822,098.68) | (255,582,342.76) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 462,223,791.00 | 511,320,991.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (264,265,790.92) | (302,026,591.36) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 33,379,665.00 | 32,708,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (29,601,818.80) | (30,987,717.20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,498,173.00 | 9,025,673.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,168,233.16) | (7,565,713.24) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,428,460,811.00 | 1,600,942,562.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (407,391,405.52) | (555,972,884.20) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 79,993,000.00 | 79,871,250.04 |
| 39301 | Програм хангамж | 487,000.00 | 487,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (121,749.96) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 79,506,000.00 | 79,506,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,796,386,883.98** | **1,776,293,435.34** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **8,175,194.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 8,175,194.00 |
| **413** | **Өглөг** | - | 8,175,194.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 1,239,694.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 6,935,500.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 6,935,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,796,386,883.98** | **1,768,118,241.34** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,796,386,883.98 | 1,768,118,241.34 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 618,069,598.00 | 618,069,598.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 618,069,598.00 | 618,069,598.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,172,843,722.08 | 1,145,174,819.44 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,172,843,722.08 | 1,173,240,296.08 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (28,065,476.64) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 5,473,563.90 | 4,873,823.90 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,796,386,883.98** | **1,776,293,435.34** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **852,993,239.00** | **732,300,397.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **288,177,439.00** | **193,876,751.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 288,177,439.00 | 193,876,751.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 288,177,439.00 | 193,876,751.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 288,177,439.00 | 193,876,751.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **564,815,800.00** | **538,423,646.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 300,744,300.00 | 317,360,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 300,744,300.00 | 317,360,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 121,730,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 121,730,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 220,010,400.00 | 99,179,700.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 220,010,400.00 | 99,179,700.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 44,061,100.00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 44,061,100.00 | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | 152,746.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 152,746.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **668,006,926.05** | **760,365,873.64** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **668,006,926.05** | **760,365,873.64** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 663,210,926.05 | 717,743,126.64 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 190,421,450.00 | 212,027,419.00 |
| 210101 | Үндсэн цалин | 190,421,450.00 | 212,027,419.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,204,758.22 | 30,258,338.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,683,698.23 | 19,957,164.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,904,207.16 | 2,111,201.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,427,585.48 | 3,587,801.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 380,839.03 | 379,768.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,808,428.32 | 4,222,402.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 80,302,819.00 | 66,225,246.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 80,252,819.00 | 65,710,246.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,000.00 | 515,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 66,453,702.00 | 65,893,884.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,179,800.00 | 921,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 39,711,040.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 662,500.00 | 230,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 64,611,402.00 | 24,938,394.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 92,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,861,500.00 | 3,666,080.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 748,080.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,861,500.00 | 2,918,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,625,500.00 | 55,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,625,500.00 | 55,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 397,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 397,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,574,457.89 | 16,579,923.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,805,017.89 | 14,508,383.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 737,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 383,100.00 | 426,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 198,000.00 | 496,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 88,340.00 | 88,340.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 254,369,738.94 | 323,037,236.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,094,974.00 | 68,582,620.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 204,274,764.94 | 254,454,616.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,796,000.00 | 42,622,747.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,796,000.00 | 41,612,746.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 152,746.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,312,000.00 | 1,460,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 40,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,484,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 1,010,001.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,010,001.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **184,986,312.95** | **(28,065,476.64)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **184,986,312.95** | **(28,065,476.64)** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **564,815,800.00** | **538,423,646.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **564,815,800.00** | **538,423,646.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 300,744,300.00 | 317,360,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 300,744,300.00 | 317,360,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 121,730,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 121,730,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 220,010,400.00 | 99,179,700.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 220,010,400.00 | 99,179,700.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 44,061,100.00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 44,061,100.00 | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | 152,746.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 152,746.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **564,815,800.00** | **538,423,646.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **564,815,800.00** | **538,423,646.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **560,019,800.00** | **486,909,005.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 190,425,441.40 | 193,732,738.00 |
| 210101 | Үндсэн цалин | 190,425,441.40 | 193,732,738.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,539,505.71 | 47,801,385.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,316,078.29 | 43,554,968.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,904,207.33 | 869,989.79 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,427,583.24 | 1,479,696.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 380,838.87 | 156,740.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,510,797.98 | 1,739,989.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 80,302,819.00 | 65,765,246.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 80,252,819.00 | 65,710,246.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,000.00 | 55,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 161,137,602.00 | 100,575,490.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 810,100.00 | 931,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 8,480,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 662,500.00 | 230,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 64,611,402.00 | 54,928,840.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 95,053,600.00 | 36,005,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,861,500.00 | 8,598,880.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 748,080.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,861,500.00 | 7,850,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,625,500.00 | 13,849,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,625,500.00 | 13,849,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 397,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 397,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,574,457.89 | 17,234,666.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,805,017.89 | 15,163,126.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 737,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 383,100.00 | 426,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 198,000.00 | 496,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 88,340.00 | 88,340.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,155,974.00 | 39,351,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,155,974.00 | 39,351,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,796,000.00** | **51,514,641.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,796,000.00 | 41,579,546.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 152,746.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,312,000.00 | 1,139,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 35,287,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,484,000.00 | 5,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 9,935,095.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9,935,095.00 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 618,069,598.00 | 5,473,563.90 | 992,067,111.81 | | 1,615,610,273.71 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (4,209,702.68) | | (4,209,702.68) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **618,069,598.00** | **5,473,563.90** | **987,857,409.13** | - | 1,611,400,571.03 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 184,986,312.95 | | 184,986,312.95 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **618,069,598.00** | **5,473,563.90** | **1,172,843,722.08** | - | 1,796,386,883.98 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **618,069,598.00** | **5,473,563.90** | **1,172,843,722.08** | - | 1,796,386,883.98 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 396,574.00 | | 396,574.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **618,069,598.00** | **5,473,563.90** | **1,173,240,296.08** | - | 1,796,783,457.98 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (599,740.00) | - | | (599,740.00) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (28,065,476.64) | | (28,065,476.64) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **618,069,598.00** | **4,873,823.90** | **1,145,174,819.44** | - | 1,768,118,241.34 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Хөтөлбөрийн код | Зориулалт, арга хэмжээний код | Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| 70101 | 80101 | **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 416540100.00 | 415530099.00 |
| 70101 | 80101 | **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 416540100.00 | 415530099.00 |
| 70101 | 80101 | **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 376540100.00 | 369390299.00 |
| 70101 | 80101 | **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0.00 | 193663708.00 |
| 70101 | 80101 | 210101 | Үндсэн цалин | 0.00 | 193663708.00 |
| 70101 | 80101 | **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0.00 | 47598585.00 |
| 70101 | 80101 | 210201 | Тэтгэврийн даатгал | 0.00 | 43352168.07 |
| 70101 | 80101 | 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 869989.79 |
| 70101 | 80101 | 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 1479696.82 |
| 70101 | 80101 | 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 156740.99 |
| 70101 | 80101 | 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.00 | 1739989.33 |
| 70101 | 80101 | **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 65765246.00 |
| 70101 | 80101 | 210301 | Гэрэл, цахилгаан | 0.00 | 65710246.00 |
| 70101 | 80101 | 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 55000.00 |
| 70101 | 80101 | **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 36163390.00 |
| 70101 | 80101 | 210401 | Бичиг хэрэг | 0.00 | 931150.00 |
| 70101 | 80101 | 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 2000000.00 |
| 70101 | 80101 | 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 230,500.00 |
| 70101 | 80101 | 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 33,001,740.00 |
| 70101 | 80101 | **2105** | **Норматив зардал** | - | 8,538,880.00 |
| 70101 | 80101 | 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 748,080.00 |
| 70101 | 80101 | 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 7,790,800.00 |
| 70101 | 80101 | **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 376,540,100.00 | 4,953,390.00 |
| 70101 | 80101 | 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад | 376,540,100.00 | 2,881,850.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | |
| 70101 | 80101 | 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 324,000.00 |
| 70101 | 80101 | 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 737,100.00 |
| 70101 | 80101 | 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 426,000.00 |
| 70101 | 80101 | 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 496,100.00 |
| 70101 | 80101 | 210807 | Газрын төлбөр | - | 88,340.00 |
| 70101 | 80101 | **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 12,707,100.00 |
| 70101 | 80101 | 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 12,707,100.00 |
| 70101 | 80101 | **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 40,000,000.00 | 46,139,800.00 |
| 70101 | 80101 | **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 40,000,000.00 | 46,139,800.00 |
| 70101 | 80101 | 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 1,139,800.00 |
| 70101 | 80101 | 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 40,000,000.00 | 40,000,000.00 |
| 70101 | 80101 | 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 5,000,000.00 |
| 70101 | 80101 | | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 416,540,100.00 | 415,530,099.00 |
| 70101 | 80101 | **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 99,179,700.00 | 99,179,700.00 |
| 70101 | 80101 | 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 99,179,700.00 | 99,179,700.00 |
| 70101 | 80101 | **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 317,360,400.00 | 316,350,399.00 |
| 70101 | 80101 | 132001 | Орон нутгийн төсвөөс | 317,360,400.00 | 316,350,399.00 |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **112,805,706.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **112,805,706.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 112,805,706.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 780,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 780,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 202,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 202,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 64,412,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,480,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 21,927,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 36,005,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 60,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 60,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,849,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,849,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,570,306.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,570,306.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,931,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,931,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 121,730,800.00 |

| | | |
|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 121,730,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 121,730,800.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын Хот тохижуулах газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын үүрэг гүйцэтгэгч түр орлон гүйцэтгэгч С.Мөнхтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдүүлэлт, сэлбэг хэрэгсэл, шатхуун зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 2 дугаар сарын 28-наас 2021 оны 03 дугаар сарын 04–ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцоoз нар хариуцаж хэрэгжүүлэв.

Байгууллагын удирдлагад хүндэтгэх зайлшгүй шалтгаан учирсны улмаас санхүүгийн тайлангийн хугацаа хоцорсон болно.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрхэм зорилго нь олон ястаны өлгий нутаг ховд хотынхоо өнгө төрх, хөгжил дэвшил цэвэр цэмцгэр байдлыг хангаж ард иргэдийн аюулгүй,таатай амьдрах орчин бүрдүүлэхийг эрхэмлэн ажиллана.

Үйл ажиллагааны чиглэл зорилт нь хот суурин газрын хог тээвэрлэх, ногоон байгууламжийг тохижилт, арчлалт, нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг угсралт, зам талбайн тохижилт үйлчилгээ , цэвэрлэгээ зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж ард иргэдийн ая тухтай орчныг бүрдүүлэх.гэж тодорхойлоод зорилтыг хэрэгжүүлэх улмаар зорилгоо хангахад үйл ажиллагаагаа чиглүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ‘’Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот ‘’Хоолны зардлын норматив тогтоох тухай’’

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын Хот тохижуулах газрын удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт,дотоод аудитын алба хяналт хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах арга хэмжээ авагдаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 760365,8 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 7603,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Жаргалант сумын Хот тохижуулах газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20093.4 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 2,084,336 | 10,892,173 | 8,807,837 |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 18,109,240 | 13,780,820 | (4,328,420) |
| Үндсэн хөрөнгө | 1,776,193,308 | 1,751,620,442 | (24,572,866) |
| **Нийт хөрөнгө** | **1,796,386,884** | **1,776,293,435** | **(20,093,449)** |
| Өр төлбөр | | 8,175,194 | 8,175,194 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,796,386,884 | 1,768,118,241 | (28,268,643) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,796,386,884** | **1,776,293,435** | **(20,093,449)** |

Өмнөх оны үзүүлэлтээс авлага 8807,8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хуучин нисэх буудлаас хүүхдийн парк хүртэлх авто замын гэрэлтүүлгийн засварын ажлын санхүүжилтийн үлдэгдэл 2950,5, арван мянгатын өндөр хөхий дэлгүүрийн хөндлөн зам дагуух гэрэлтүүлгийн засварын ажлын үлдэгдэл санхүүжилт

2985,0, хур хог хаягдлын санхүүжилтийн үлдэгдэл 2989,5 нийт 8925,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой.

Бараа материал дансны үлдэгдэл 4328,4 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал дансны үлдэгдлээс хамаарч байгаа ба энэ нь оны эхний үлдэгдлээр байсан хэмжээнээс 12 тн буюу 4200,0 мянган төгрөгийн давсыг зам талбайн халтиргаа гулгаанд цацаж зарцуулснаас буурчээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24572,8 мянган төгрөгөөр буурсанд тайлант жилийн элэгдлийн зардал 254454,6 мянган төгрөг ихээхэн нөлөө үзүүлж байгаа, аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 223 тоот тогтоолоор 157088,0 мянган төгрөгийн өргөх тавцантай авто машин 37900,0, Тоёота альфарт маркын суудлын авто машин 19500,0 нийт 57400,0 мянган төгрөгийн хөрөнгө орлого авч данс бүртгэлд тусгасан, ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 306, 310 тоот тогтоолоор талбай тойрсон барилгуудын хананд суулгасан талбайн гэрэлтүүлэг 152981,7, жаргалан багийн 30 айлын сууц орчмын талбайн тохижилтын явган зам, тоглоомын талбайн саравч гэх мэтийн нийтийн эзэмшлийн хөрөнгө 19500.0 нийт 172481.7 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд орлого бүртгэсэн байна.

Жаргалант сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 209 тоотоор 1144,1 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж акталсан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 4 сарын 24-ны өдрийн 116 тоот тогтоолоор нээлттэй дуудлага худалдаагаар портер маркийн 8302,8 мянган төгрөгийн үнэтэй авто машиныг дуудлага худалдаагаар зарсан тул данснаас хассан байна. Эдгээр хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн нөлөөллөөс үндсэн хөрөнгө данс дүнгээрээ буурсан байна.

Өглөг данс 8175,2 мянган төгрөгөөр өссөн нь буцаан төвлөрүүлсэн орлогоос санхүүжүүлэхээр байсан ажил үйлчилгээний төлбөр цаг хугацаандаа хийгдээгүйгээс үүссэн байна.

Хүснэгт 2 Орлогын үзүүлэлтүүд

Жаргалант сумын Хот тохижуулах газрын нийт орлого өмнөх оноос 120692.8 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар буурчээ.

| Үзүүлэлт | өмнөх оны | тайлант оны | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт | 332,932,500 | 317,360,400 | (15,572,100) |
| Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт | 99,179,700 | 99,179,700 | - |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө | 288,177,439 | 193,876,751 | (94,300,688) |
| бусад сан, санхүүжилтээс | 132,703,600 | 152,746 | (132,550,854) |
| Засаг даргын нөөц сангаас . | | 121,730,800 | 121,730,800 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **852,993,239** | **732,300,397** | **(120,692,842)** |

Орон нутгийн төсвийн санхүүжилт 15572,1 мянган төгрөгөөр буурсан энэ нь хур хог хаягдал хөтөлбөр арга хэмжээний санхүүжилт буурсан, бусад орлого санхүүжилт 105120,7 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө бэлтгэхтэй холбоотой зардлаас хамааралтай байна.

Хүснэгт 3 зардлын үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | өмнөх оны | тайлант оны | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ | 217,626,208 | 242,285,757 | 24,659,549 |

| | | | |
|---|---|---|---|
| Байр ашиглалттай холбоотой зардал | 80,302,819 | 66,225,246 | (14,077,573) |
| Хангамж бараа материалын зардал | 66,453,702 | 65,893,884 | (559,818) |
| нормативт зардал | 5,861,500 | 3,666,080 | (2,195,420) |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 297,762,697 | 381,284,905 | 83,522,208 |
| бусад урсгал шилжүүлэг | | 1,010,001 | 1,010,001 |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **668,006,926** | **760,365,873** | 92,358,947 |

Нийт зардал өмнөх оноос 92358,9 мянган төгрөгөөр буюу 13,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 24659,5 өссөн нь цалингийн нэмэгдэх өөрчлөлт орсон болон, 3 орон тоо нэмэгдсэн, удаан жилийн нэмэгдэл урамшуулал олгох болсон зэрэгтэй холбоотой байна.

Бусад урсгал зардал 67699,3 мянган төгрөгөөр өссөн нь гудамж талбайн гэрэлтүүлэг засвар, тохижилтын ажлын хэмжээ өссөнөөс хамаарсан байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 416540,0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 416540,0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 416540,0 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 416540,0 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 317360,4 орон нутгийн хөгжлийн сангаас 99179,6 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 317360,4 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн хөгжлийн сангаас 99179,6 мянган төгрөг нийт 416540,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 415530,0 мянган төгрөгийг зарцуулж 1010,0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлангийн хугацаанд нэмэлт дансаар 7 гэрээт ажлын 121730,8 мянган төгрөг орон нутгийн хөрөнгө оруулалтаас орж 112805,7 мянган төгрөгийг хур хог зайлуулах, зам гаргах, гэрэлтүүлэг засварын ажил, нохой устгах, өргөх тавцантай авто машин авах, цэцэг тарих, тээвэрлэх ажилд тус тус зарцуулж 8925,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

### 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд горим сорил хэрэгжүүлээгүй болно.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрийн орлогоос хамаарч төсөв хэтэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн нь хэрэгжсэн байна.

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10834,9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 802,9 мянган төгрөгийн алдааг залруулж, бараа материалын тайлан, сэлбэг хэрэгсэл, шатахуун зарцуулалттай холбоотой 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталсан хөрөнгөнд ногдох дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилтийг бүртгээгүй 599.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн ангилал зөрүүтэй тайлагнаж илүү шилжүүлсэн 203.1 мянган төгрөгийн залруулгыг хийлээ.

- Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа байхгүй

- Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:

Жаргалант сумын болон Хот тохижуулах газрын дансанд тусгагдаагүй боловч хот тохижуулах газар хогийн цэгийн цэвэрлэгээнд ашиглаж байгаа 50 ковш эвдрэл ихтэй сэлбэг хэрэгсэл шатахуун зарцуулалт хяналтгүй үрэлгэн байна. Энэ асуудлыг дахин шалгах шаардлагатай байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**Зардлын данстай холбоотой асуудал.**

1.1. **Илрүүлэлт:** Эд хариуцагчийн тайлан тооцоогоор хог хаягдал отволдох ажилд ашиглаж байгаа 50 ковшид тайлангийн хугацаанд 10,0 гаруй сая төгрөгийн өндөр үнэ бүхий сэлбэг хэрэгслийг ашиглалтын норматив хэмжээгүйгээр зарцуулжээ.

1.2. **Эрсдэл:** Төсвийн үрэлгэн зарцуулалт үүсэх

1.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.3-д заасан зохистой удирдлага, хариуцлагатай байдлыг хангаж ажиллах

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар**: Зөвшөөрч байна.

2.1. **Илрүүлэлт**: Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

**2.2. Эрсдэл:** тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

2.3. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар** Зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн/ мян.төг/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Дахин үнэлгээний нэмэгдлийн залруулга | 599,7 | залруулга | Нягтлан бодогч | С.Мөнхтуяа |
| 2 | НДШимтгэлд ангилал буруу тооцож илүү шилжүүлсэн дүнг залруулсан | 203,1 | залруулга | Нягтлан бодогч | С.Мөнхтуяа |
| 3 | 50 новшинд / тодорхой эзэнгүй/ сэлбэг хэрэглэл гидрийн шингэнд хяналтгүй лимитгүй зарцуулсан | 10,032,0 | зөвлөмж | Нягтлан бодогч | С.Мөнхтуяа |
| 4 | НӨАТ-н баримт дутуу | - | Зөвлөмж | Нягтлан бодогч | С.Мөнхтуяа |
| | НИЙТ ДҮН | 10,834,9 | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**